

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

НИЙСЛЭЛИЙН СПОРТЫН ХОРООНЫ 2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: НТАГ-2020/578/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2020 он

Монголиан Бизнес Рейтинг Аудит ХХК-ийн

Ерөнхий захирал: Д.Түмэнжаргал

Утас: 70005329 Цахим хаяг: mbr.audit.llc@gmail.com

Аудитын менежер: Д.Нямдорж

Утас: 70005329 Цахим хаяг: mbr.audit.llc@gmail.com

Аудитор: Т.Батсайхан

Утас: 70005329 Цахим хаяг: mbr.audit.llc@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

ҮАГ	Үндэсний аудитын газар
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч

1. Агуулга	
1. Аудитын гэрчилгээ.....	3
2. Аудитын тайлан	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал.....	10
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	14
4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	16
4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	18
4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	21
4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	22
4.6. Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэлийн тайлан.....	24

Аудитын гэрчилгээ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.city.audit.mn

2020.02.20 № 236
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН СПОРТЫН ХОРООНЫ
ДАРГА, ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
Ж.ГАНБОЛД ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн спортын хорооны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Нийслэлийн спортын хорооны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нийслэлийн спортын хорооны 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын

D:\Documents\Documents\2020 onlywuisan bichigt\2020.02.18 N-Sportin хороо.docx

002020131

Аудитын гэрчилгээ

хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын Стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.МӨНХ-ОЧИР

2.1. Оршил

Нийслэлийн спорт хорооны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Нийслэлийн спорт хорооны дарга Ж.Ганболд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, программ хангамжийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заасны дагуу Нийслэлийн спорт хорооны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд НТАГ-тай байгуулсан гуравласан гэрээг үндэслэн аудит хийлээ.

Нийслэлийн спорт хорооны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 05-наас 2020 оны 2 дугаар сарын 16-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, "Монголиан бизнес рейтинг аудит" ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Нийслэлийн спорт хорооны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг "Монголиан бизнес рейтинг аудит" ХХК 2020 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 2/27 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Нийслэлийн спортын хорооны үйл ажиллагааны эрхэм зорилго нь Биеийн тамир, спортын үйлчилгээг нийслэл хотын айл өрх, иргэн бүрт хүргэж, өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэх орчин, нөхцлийг бүрдүүлэхэд оршино.

Нийслэлийн спортын хороо үйл ажиллагааны чиглэлдээ шударга, ил тод, хуулийг дээдлэх, мэдлэг чадвартай, мэргэшсэн тогтвортой, хариуцлага, ёс зүйтэй, бүтээлч, санаачлагатай, иргэд, олон нийтэд түшиглэх, хяналт үр дүнг чухалчлах зарчуудмыг эрхэмлэнэ гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд татварын хөнгөлөлт
- Нийгмийн даатгалын тухай хуульд шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт орсныг хэрэгжүүлж ажилласан байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

Нийслэлийн спортын хороо санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн боловсруулсан "Acolous 3.0", программ хангамж ашигладаг байна.

Нийслэлийн спорт хорооны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Нийслэлийн спорт хорооны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй

нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 22 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 811,572.9 мянган төгрөгөөс тооцон 8,115.7 төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 8,729.7 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт зардлын дүн 61,401.1 мянган төгрөг буюу 7.6 хувиар өссөнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Нийслэлийн спорт хорооны 2019 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,285.6 мянган төгрөгөөр буюу 3.4 хувиар буурсан байна. Оны эхний болон эцсийн үзүүлэлтийг харьцуулахад бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмч дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	16,289.8	9,503.2	-6,786.6
Үндсэн хөрөнгө	166,261.6	166,762.6	501.0
Нийт хөрөнгө	182,551.4	176,265.8	-6,285.6
Өр төлбөр	-	4,172.4	4,172.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	182,551.4	172,093.4	-10,457.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	182,551.4	172,093.4	-10,457.9

Бараа материалын дансны үлдэгдэл 6,786.6 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны бараа материалын үлдэгдлийг зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 501.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд 5,140.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлдэж, 4,638.9 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 4,172.4 мянган төгрөг нь нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 3,126.1 мянган төгрөг, ХХОАТ-ын өглөг 1,046.3 мянган төгрөгийн төлбөрийг төлөөгүйтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 172,093.4 мянган төгрөг болж 10,457.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд ТШЗ-ийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 418,456.2 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагдаж нийт зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төсөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5 харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 369,540.2 мянган төгрөг буюу 88.3 хувьтай байгаа нь бараа үйлчилгээний зардлын хэмнэлт 48,915.9 мянган төгрөгийн зардлын хэмнэлттэй холбоотой байна.

Тус байгууллагын төсвийн захирагч нь 2019 онд 418,456.2 мянган төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагааны урсгал зардалд 369,540.2 мянган төгрөг зарцуулж, үлдэгдэл 48,915.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Нэмэлт төсөв: Засаг даргын нөөц хөрөнгөөс 385,965.9 мянган төгрөг, Нийслэлийн Засаг даргын захирамжаар 4,440.0 мянган төгрөгийг Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн уралдаан тэмцээний санхүүжилт, Олон Улсын уралдаан тэмцээн зохион байгуулахад аж ахуй нэгж төрийн бус байгууллагуудаас 66 удаагийн гүйлгээгээр марафон тэмцээний хураамж 57,826.4 мянган төгрөгийг авч, нийт 448,232.2 мянган төгрөгийн орлоготой байна.

Нэмэлт төсвийн зардлын зарцуулалтыг зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.6-д харуулав.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 22 эрсдэл тогтоож, гүйцэтгэх үе шатанд нийт 22 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 4,172.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 4,172.4 мянган төгрөгийн алдааг залруулж, зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө. Үүнд:

Тайлант оны нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг 3,126.1 мянга, ХХОАТ-ын өглөгийг 1,016.3 мянган төгрөгөөр тус тус дутуу бүртгэж тайлагнасан нь хэмжилт, үнэн зөв байдал, үнэлгээ эрх үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй,

УСНББОУС-1 болон 19, Нягтлан болох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 2019 оны санхүүгийн тайланд алдааг залруулга хийлгэсэн.

Аудитаар илэрсэн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Татвар, нийгмийн даатгалын өглөгийг санхүүгийн тайланд толилуулдаггүй тул анхаарал татахуйц асуудлыг дараагийн аудитаар хянаж үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Нийслэлийн спорт хороо нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасны дагуу 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар болон shilendans.gov.mn нэгдсэн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Нийслэлийн спорт хороон нь шилэн дансны нэгдсэн цахим системд 2019 онд 139 мэдээллийг хугацаанд нь, 24 мэдээллийг хугацаа хоцроож, 3 мэдээллийг байршуулаагүй байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар нийт 6 заалт бүхий зөвлөмж өгснөөс 5 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжээгүй буюу зөвлөмжийн хэрэгжилт 80 хувьтай байна. Хөрөнгийн элэгдлийг дутуу байгуулсан 1,414.2 мянган төгрөгийн зөвлөмж хэрэгжээгүй байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Нийслэлийн спорт хорооны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Нийслэлийн спорт хорооны 2019 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дүгээр хэсгийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

3.1.1 Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь тухайн байгууллагын онцлог, үйл ажиллагаатай уялдаж байгаа хэдий ч Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох хууль, эрх бүхий байгууллагаас гаргасан заавар, журмын дагуу шинэчлэгдээгүй. Энэ нь үнэн зөв байдал, иж бүрэн байх, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдлийг хангаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалтай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан заавар, журам зөрчигдөх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг хууль тогтоомж, стандарт, дүрэм, журамд нийцүүлэн шинэчилж байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн хариу тайлбарыг албан бичгээр ирүүлсэн.

3.2 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

3.2.1 Илрүүлэлт:

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа программ хангамж нь Сангийн яам, Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газар, шилэн дансны системтэй уялдаагүй, мэдээлэл солилцох боломжгүй байна.

Энэ нь үнэн зөв байдал, иж бүрэн байх, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдэл, Сангийн сайдын 2018 оны 47 дугаар тушаалаар баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага"-ын 1.4-1.7-д заасан шаардлагуудтай нийцээгүй.

3.2.2 Эрсдэл:

Тайлан мэдээ хугацаа алдаж гарах, буруу илэрхийлэгдэх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн программд шаардлагатай шинэчлэлтийг хийлгүүлж байх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн хариу тайлбарыг албан бичгээр ирүүлсэн.

3.3. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

3.3.1. Илрүүлэлт:

"Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн 2003 онд боловсруулсан "Acolous 3.0" хуучин программыг нягтлан бодох бүртгэлд ашиглаж байгаа нь ашиглалтын шаардлага хангахгүй, элэгдлийг буруу тооцож байна. Энэ нь үнэн зөв байдал, иж бүрэн байх, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдэл, Сангийн сайдын 2018 оны 47 дугаар тушаалаар баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага"-ын 1.4-1.7-д заасан шаардлагуудтай нийцээгүй.

3.3.2. Эрсдэл:

Хууль тогтоомж, стандарт, дүрэм журам, зөрчигдөх, санхүүгийн бүртгэл тайлан буруу илэрхийлэгдэх.

3.3.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн программд шаардлагатай шинэчлэлтийг хийлгүүлж байх

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн хариу тайлбарыг албан бичгээр ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 5 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

Хянасан:

Санхүүгийн аудитын хэлтсийн дарга бөгөөд

аудитын менежер

Аудитын менежер



Бэлтгэсэн:

“Монголиан бизнес рейтинг аудит” ХХК-ийн

Ерөнхий захирал

Аудитор



Д.Түмэнжаргал

Т.Батсайхан

Үйлчлүүлэгч байгууллагын хариу:



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
СПОРТЫН ХОРОО

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
Ж.Самбуугийн гудамж, Бага тойруу 15,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 31-27-85, Факс: (976-11) 32-89-77
E-mail: it@sport.ub.gov.mn
http://www.sport.ub.gov.mn

2020.02.19 № 2/35
танай _____-ны № _____-т

МОНГОЛИАН БИЗНЕС
РЕЙТИНГ АУДИТ ХХК-Д

Манай байгууллагын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа зөрчилтэй танилцаж гарсан алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрч байна.

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Хавсралт 1. хуудастай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ГАНБОЛД

D:\M.Tsogzolmaa\2020\alban toot\Alban toot A5.docx

1150500023

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	16,289,822.00	9,503,250.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
33	АВЛАГА	00.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	16,289,822.00	9,503,250.00
354	Хангамжийн материал	16,289,822.00	9,503,250.00
35410	Бичиг хэргийн материал	12,579,050.00	857,200.00
35420	Аж ахуйн материал	3,670,772.00	4,421,372.00
35470	Бусад хангамжийн материал	40,000.00	4,224,678.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	166,261,574.83	166,762,582.67
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	166,261,574.83	166,762,582.67
392	Биет хөрөнгө	13,761,574.83	14,437,582.67
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	28,831,102.00	29,371,102.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-22,442,868.67	-23,733,848.71
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	42,853,379.90	47,453,379.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	-35,480,038.40	-38,653,050.52
393	Биет бус хөрөнгө	152,500,000.00	152,325,000.00
39301	Программ хангамж	1,780,000.00	1,780,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-580,000.00	-755,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	151,300,000.00	151,300,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	182,551,396.83	176,265,832.67
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	4,172,432.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	4,172,432.0
413	Өглөг	00.00	4,172,432.0
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	4,172,432.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	182,551,396.83	172,093,400.67
51	Засгийн газрын хувь оролцоо	182,551,396.83	172,093,400.67
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	209,311,395.49	209,311,395.49
51101	Өмч: - төрийн	209,311,395.49	209,311,395.49
512	Хуримтлагдсан үр дүн	-26,759,998.66	-37,217,994.82
51210	Өмнөх үеийн үр дүн	-26,759,998.66	-26,759,998.66
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-10,457,996.16
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	182,551,396.83	176,265,832.67

4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	820,830,091.15	866,688,450.78
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
110	Орлогын албан татвар	00.00	00.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	00.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	820,830,091.15	866,688,450.78
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	422,077,900.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	422,077,900.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	398,752,191.15	448,232,250.78
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	68,746,991.15	57,826,387.78
131103	ЗАНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	290,259,200.00	385,965,863.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,746,000.00	4,440,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	418,456,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	418,456,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	811,572,972.34	877,146,446.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	811,572,972.34	877,146,446.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	792,433,505.19	826,730,539.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	130,751,107.00	133,127,639.00
210101	Үндсэн цалин	118,751,107.00	113,127,639.00
210102	Нэмэгдэл	00.00	14,179,272.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,000,000.00	5,485,399.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,945,700.00	15,993,749.00
210201	Тэтгэврийн даатгал	12,918,303.00	11,136,880.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,382,397.00	1,221,417.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	552,000.00	969,374.00
210204	Ажилгүйдлийн даатгал	138,000.00	242,443.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,955,000.00	2,423,635.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,400,000.00	8,100,961.00
210304	Байрны түрээс	12,000,000.00	8,100,961.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,930,502.00	22,337,189.00
210401	Бичиг хэрэг	2,100,502.00	14,419,600.00
210402	Тээвэр, шатахуун	9,230,000.00	5,424,182.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,600,000.00	2,069,707.00
210404	Ном, хэвлэл	00.00	00.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	423,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	80,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	80,000.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	650,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	650,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	412,510,027.00	450,095,247.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	410,784,689.00	444,983,580.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,371,738.00	4,524,067.00
210807	Газрын төлбөр	353,600.00	587,600.00

Нийслэлийн Спорт хорооны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	201,896,169.19	196,345,754.16
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	194,571,538.00	187,720,762.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	3,986,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,324,631.19	4,638,992.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,139,467.15	50,415,907.78
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,800,000.00	1,500,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,800,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,339,467.15	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,339,467.15	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	48,915,907.78
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	48,915,907.78
213404	Хөрөнгийн	00.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	9,257,118.81	-6,285,564.16
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	00.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	9,257,118.81	-10,457,996.16

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	820,830,091.15	866,688,450.78
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
110	Орлогын албан татвар	00.00	00.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	00.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	820,830,091.15	866,688,450.78
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	422,077,900.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	422,077,900.00	00.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	00.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	398,752,191.15	448,232,250.78
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	68,746,991.15	57,826,387.78
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	290,259,200.00	385,965,863.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,746,000.00	4,440,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	418,456,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	418,456,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	814,375,191.15	861,548,450.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	814,375,191.15	861,548,450.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	795,235,724.00	811,132,543.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	130,751,107.00	129,660,161.00
210101	Үндсэн цалин	118,751,107.00	126,777,930.00
210102	Нэмэгдэл	00.00	1,981,231.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,000,000.00	901,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,945,700.00	15,288,795.00
210201	Тэтгэврийн даатгал	12,918,303.00	9,512,795.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,382,397.00	1,444,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	552,000.00	1,155,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	138,000.00	289,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,955,000.00	2,888,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,400,000.00	8,100,961.00
210301	Гэрэл, цахилгаан	2,400,000.00	00.00
210304	Байрны түрээс	12,000,000.00	8,100,961.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,880,100.00	9,462,839.00
210401	Бичиг хэрэг	1,880,100.00	1,968,950.00
210402	Тээвэр, шатахуун	6,200,000.00	5,424,182.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,600,000.00	2,069,707.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,200,000.00	00.00
2105	Нормативт зардал	00.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	259,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	259,000.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	650,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	650,000.00

Нийслэлийн Спорт хорооны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	424,251,827.00	455,626,925.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	422,526,489.00	452,407,250.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,371,738.00	2,632,075.00
210807	Газрын төлбөр	353,600.00	587,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	195,006,990.00	192,083,862.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	195,006,990.00	188,097,862.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	3,986,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,139,467.15	50,415,907.78
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,800,000.00	1,500,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,800,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,339,467.15	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,339,467.15	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	48,915,907.78
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	48,915,907.78
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	6,454,900.00	5,140,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	6,454,900.00	5,140,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,454,900.00	5,140,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,454,900.00	5,140,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,454,900.00	5,140,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-6,454,900.00	-5,140,000.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
14	Бусад эх үүсвэр	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

Нийслэлийн Спорт хорооны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	58,011,395.49	00.00	-36,017,117.47	00.00	21,994,278.02
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	58,011,395.49	00.00	-36,017,117.47	00.00	21,994,278.02
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	151,300,000.00	00.00	00.00	00.00	151,300,000.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	9,257,118.81	00.00	9,257,118.81
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	209,311,395.49	00.00	-26,759,998.66	00.00	182,551,396.83
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	209,311,395.49	00.00	-26,759,998.66	00.00	182,551,396.83
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-10,457,996.16	00.00	-10,457,996.16
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	209,311,395.49	00.00	-37,217,994.82	00.00	172,093,400.67

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Төлөв	Гүйц		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	418,456,200.00	369,540,293.00	48,915,907.00	88.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	418,456,200.00	369,540,293.00	48,915,907.00	88.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	416,956,200.00	368,040,293.00	48,915,907.00	88.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	168,295,400.00	129,660,161.00	38,635,239.00	77.0
210101	Үндсэн цалин	132,888,100.00	126,777,930.00	6,110,170.00	95.4
210102	Нэмэгдэл	24,595,300.00	1,981,231.00	22,614,069.00	8.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,812,000.00	901,000.00	9,911,000.00	8.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,662,000.00	15,288,795.00	6,373,205.00	70.5
210201	Тэтгэврийн даатгал	14,730,100.00	9,512,795.00	5,217,305.00	64.5
210202	Тэтгэмжийн даатгал	1,733,000.00	1,444,000.00	289,000.00	83.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,386,400.00	1,155,000.00	231,400.00	83.3
210204	Ажилгүйдлийн даатгал	346,600.00	289,000.00	57,600.00	83.3
210205	Эрүүл мэндийн даатгал	3,465,900.00	2,888,000.00	577,900.00	83.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,915,300.00	10,525,961.00	389,339.00	96.4
210301	Гэрэл, цахилгаан	915,300.00	00.00	915,300.00	
210304	Байрны түрээс	10,000,000.00	10,525,961.00	-525,961.00	105.2
2104	Хангамж, бараа материалын зардал	9,600,000.00	9,462,839.00	137,161.00	98.5
210401	Бичиг хэрэг	1,800,000.00	1,968,950.00	-168,950.00	109.3
210402	Тээвэр, шатахуун	5,800,000.00	5,424,182.00	375,818.00	93.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.00	2,069,707.00	-69,707.00	103.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	259,000.00	741,000.00	25.9
210604	Урсгал засвар	1,000,000.00	259,000.00	741,000.00	25.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,080,000.00	10,759,675.00	320,325.00	97.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	7,000,000.00	7,000,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,250,000.00	3,172,075.00	77,925.00	97.6
210807	Газрын төлбөр	830,000.00	587,600.00	242,400.00	70.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	194,403,500.00	192,083,862.00	2,319,638.00	98.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	188,403,500.00	188,097,862.00	305,638.00	99.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,000,000.00	3,986,000.00	2,014,000.00	66.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	00.00	0.00	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	418,456,200.00	369,540,293.00	48,915,907.00	88.3
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				-
131001	Улсын төсвөөс санхүүжих				-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	418,456,200.00	369,540,293.00	48,915,907.00	88.3

Нийслэлийн Спорт хорооны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

132001	Орон нутгийн төсвөөс	418,456,200.00	369,540,293.00	369,540,293.00	-	88.3
1330	Ажиллагсдын тоо	8	8		-	100.0
133001	Удирдах ажилтан	1	1		-	100.0
133002	Гүйцэтгэх ажилтан	7	7		-	100.0

4.6. Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Төл	Гүйц	Зөрүү
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	448,232,250.00	-
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	448,232,250.00	-
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	448,232,250.00	-
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	00.00	-
2107	Томиллолт, зочны зардал	-	650,000.00	-
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	650,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	447,582,250.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	447,582,250.00	-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	448,232,250.78	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	448,232,250.78	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	57,826,387.78	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	385,965,863.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,440,000.00	-
131106	Төсвийн урамшуулал	-	00.00	-
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-

**Санхүүгийн тайлангийн аудитын хураангуй
тайлан**

Огноо: 2020.02.18

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	САГ-2020/578/СТА-ТШЗ	Шалгагдсан байгууллага, нэгжийн нэр:	Нийслэлийн спортын хороо
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	"Монголиан бизнес рейтинг аудит" ХХК	Аудит хийсэн баг, албан тушаалтан	Ерөнхий захирал Д.Түмэнжаргал ЧХ-ны менежер Д.Нямдорж Аудитор Т.Батсайхан Туслах аудитор Д.Энхжаргал
Аудитын нэр:	Нийслэлийн спортын хорооны 2019 оны санхүүгийн тайлангийн аудит		

Хоёр. Байгууллага, нэгжийн тоо болон санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр/ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Гаргасан санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудит хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт	Итгэл үзүүлсэн					Аудит хийгээгүй
A	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Нийслэлийн спортын хороо	1	1	-	-	-	1			
	ДҮН									

Гурав. Аудитын үр дүн

3.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг ач холбогдлоор нь эрэмбэлж танилцуулах:

<p>Алдаа, зөрчилтэй асуудал 1 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан заавар, журамтай нийцэхгүй байна.</p> <p><u>Шийдвэрлэсэн нь:</u> Менежментийн захидлаар зөвлөмж өгөх</p> <p>Алдаа, зөрчилтэй асуудал 2 "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн 2003 онд боловсруулсан "Acolous 3.0" хуучин программыг нягтлан бодох бүртгэлд ашиглаж байгаа нь ашиглалтын шаардлага хангахгүй, үндсэн хөрөнгийн элэгдлийг буруу тооцож байна.</p> <p><u>Шийдвэрлэсэн нь:</u> Менежментийн захидлаар зөвлөмж өгөх</p>
